



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот

Г “Хот тохижилтын газар” орон нутгийн Г  
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/684 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 2,018,936,559.56 (хоёр тэрбум арван найман сая есөн зуун гучин зургаан мянга таван зуун тавин ес төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 14 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 18,126,100.00 (арван найман сая нэг зуун хорин зургаан мянга нэг зуу) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 5,437,830.00 (таван сая дөрвөн зуун гучин долоон мянга найман зуун гуч) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА  В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2025 оны 05 дугаар сарын 22-ны  
өдрийн .../186... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Автомашинны марк	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдан борлуулах доод үнэ
1	Zoomlion 27-67 УНБ	257,925,000.00	257,925,000.00	-	1,319,200.00
2	Isuzu FTR33 72-02 УБЕ	69,038,080.00	69,038,080.00	-	1,234,600.00
3	Самосвал /6тн/ 72-06 УБЕ	106,496,000.00	106,496,000.00	-	1,269,600.00
4	Самосвал /6тн/ 72-08 УБЕ	106,496,000.00	106,496,000.00	-	1,269,600.00
5	HYUNDAI HD- 120 04-23 УНП	89,725,000.00	89,725,000.00	-	1,376,700.00
6	HYUNDAI HD- 120 06-25 УНП	89,725,000.00	89,725,000.00	-	1,376,700.00
7	Babcat S770B 62-91 УН	109,200,000.00	109,200,000.00	-	1,252,700.00
8	Hyundai Porter 46-41 УНЕ	37,100,000.00	37,100,000.00	-	638,400.00
9	Haide CHD5021 00-74 УР	142,500,000.00	75,911,572.38	66,588,427.62	371,800.00
10	Haide CHD5021 00-53 УР	142,500,000.00	75,911,572.38	66,588,427.62	371,800.00
11	Dong Feng 89-12 УБВ	225,115,739.78	180,240,535.48	44,875,204.30	2,186,400.00
12	Dong Feng 89-52 УБВ	225,115,739.78	180,240,535.48	44,875,204.30	2,186,400.00
13	МАК 438043 39- 52 УАЕ	209,000,000.00	111,565,837.50	97,434,162.50	1,636,100.00
14	МАЗ 438043-340- 201 39-42 УАЕ	209,000,000.00	111,565,837.50	97,434,162.50	1,636,100.00
Дүн		2,018,936,559.56	1,601,140,970.72	417,795,588.84	18,126,100.00
Төвлөрүүлэх дүн					5,437,830.00